

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Зүүн болон Өмнөд Африкийн эмэгтэйчүүдийн төлөөх залбирал 1

TWR Найдвар доторх Эмэгтэйчүүдийн үйлчлэл нь Танзанийн эх газрын 11 бүс нутаг болон Занзибар, Пемба гэсэн хоёр арал дээр үйлчлдэг. Танзани дахь хамгийн сүүлийн мэдээллээр TWR "Найдвар доторх эмэгтэйчүүд үйлчлэл" Пемба аралд эхэлсэн. Пембагийн үйлчлэлийг эхлүүлсэн даруйдаа Бурхан Пемба хотын хоёр радио станцаар "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг дамжуулахын тулд энэ жилийн санхүүгийн бүх боломжуудыг нээж өгсөн. Тиймээс та бид Бурхан муслым сонсогчид нэвтрүүлэгийн сүнслэг агуулгыг сонсож, тэдний амьдралд Бурханы үг үр болон таригдахын тулд тэдний зүрх сэтгэл нээгдэхийн төлөө залбирцгаая.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Эзэн минь, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод өөрсдийгөө ямар нэг байдлаар мөлжлөгт өртөж байгаагаа ойлгоход нь туслаач. Тэднийг хүчирхийлэлд өртөж байгааг нь эрт илрүүлж, тусалж чадах хүмүүстэй холбогдоход Аав аа Та туслаач. (Лук 4:18)
2. Эзэн минь, Өмнөд Африкийн Зүүн Кейп мужид гэр бүлээрээ доромжлуулж, амьд үлдэхийн төлөө тэмцэж буй бэлэвсэн эмэгтэйчүүдийг хамгаалж, халамжлагч нь Та байгаарай. (Флп. 4:19)
3. Бурунди улсад охин төрүүлснийхээ төлөө гэр бүлийн удам угсаа тасарсанд буруутгагдаж, зөвхөн эмэгтэйчүүдийг тайтгаруулж, тэнхрүүлэгч нь Та байгаач Аав аа. (Эх. 1:27)
4. Аав аа, бид таныг TWR-ийн Найдвар доторх Эмэгтэйчүүд Эсватинид үйлчлэлийн багийг байгуулахад Та туслаач хэмээн залбирч байна. (Ром. 12:6-8)

5. Бурхан минь, энэ 7-р сард их сургуулиа төгсөх Танзани дахь залуучуудын ажлын байр бэлтгэгдсэн байхын төлөө залбирч байна. (Сур. 16:9)
6. Эзэн минь, Сомали дахь залуу охидууд хүүхэд төрүүлэх явцдаа төрөхийн хүндрэл, цаашлаад амь насаа алдаж байна. Охидыг эрт гэрлэхээс хамгаалсан соёлын өөрчлөлт бий болохын төлөө бид залбирч байна. (Дуу. 138:7)
7. Этиоп улсын Амхара бүс нутгийг дайны хөлөөс Та хамгаалаач хэмээн бид залбирч байна. Тэнд амьдарч буй хүмүүст та бүхний амар амгалан байх болтугай. (Ис. 2:4)
8. Бурхан минь, Зимбабвегийн эмэгтэйчүүд, хүүхдүүдийг архи, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэснээс үүдсэн гэмтлээс тэдний овун бодол, зүрх сэтгэлийг хамгаалаач. (Сур. 23:18)
9. Бурхан минь, Ботсванад эмэгтэйчүүд Христийг сонгож, Түүнтэй илүү гүнзгий харилцаатай байж, зорилгодоо хөтлөгдсөн амьдралаар амьдраасай гэж бид залбирч байна. (Еф. 2:10)
10. Аав аа, Өмнөд Африкийн хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдэд нарны эрчим хүчээр ажилладаг аудио тоглуулагч бэлэглэсэнд баярлалаа. Найдвар доторх эмэгтэйчүүд хөтөлбөрийг сонсодог хүмүүс сүнслэгээр өсөх болтугай. (2 Петр. 3:18)
11. Эзэн минь, Бурунди улсад буруугаар ойлгогддог, байнга зодуулж байдаг аутизмтай хүүхдүүдийг хамгаалаач. Эцэг эхчүүдэд хүүхдүүд нь яагаад хичээлдээ муу байгааг, тэдний ялгаатай байдлыг харж ойлгоход нь Та тэдний нүдийг нээгээч. (Дуу. 46:1)
12. Бурхан минь, бид Танаас Эсватинид, ялангуяа газар тариалан эрхэлж байгаа бүс нутагт бороо оруулж, үр жимсигй ургуулаач хэмээн залбирч байна. (Лев. 26:4)
13. Мөнхийн Эзэн минь, бид Танзани улсад эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх хор хөнөөлтэй уламжлалт зан үйлийг устгахын төлөө залбирч байна. (Кол. 2:8)
14. Аав аа, Сомалид сайн мэдээг түгээх үүд хаалгыг нээж өгсөнд баярлалаа. Есүсийн нэрээр тэнд үйлчлэхийн тулд TWR-ийн Найдвар доторх Эмэгтэйчүүд үйлчлэлийг ашиглаач. (Марк 13:10)
15. Бурхан минь, Өмнөд Африкийн хот тосгонд байгаа бүлэглэлийн гишүүдийн гарт олон хүн амиа алдаж буй эмэгтэйчүүд, хүүхдүүдийн төлөө залбирч байна. Тэдний хэрцгий нэгний гараас Та хамгаалаач. (Дуу. 18:2)



16. Этиоп улсад эдийн засгийн хямралын улмаас ядуурал газар авч, доройтож байгаа энэ цаг үед гэр бүлээ тэжээх боломжгүй ядуу гэр бүл, бэлэвсэн эхнэрүүдэд тусламж үзүүлэх бүх боломжийг Та нээж өгөөч. (Лук 3:11)
17. Бурхан минь, Зимбабвегийн инфляцийн улмаас гэр бүл нь харж хандах боломжгүй байгаа өндөр настнуудын тэтгэвэр тэтгэмж багасч, амьдрахалд хүндрэлтэй байгаа энэ үед тэднийг тайтгаруулж, хангагч нь Та байгаач. (1 Тим. 5:8)
18. Аав аа, Ботсвана дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүст цэвэр ариун хэвээр үлдэх хүсэл, хүч чадлыг өгч, хамтран амьдрахаас илүү гэрлэлтийг сонгох нь чухал гэдгийг ойлгоход нь Та туслаач. (1 Кор. 7:2)
19. Аав аа, таныг Өмнөд Африкт хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд хүч чадал, урам зориг хайрлаач гэж залбирч байна. (Дэд хууль 31:6)
20. Бурхан минь, Бурунди улсад эмэгтэйчүүдийг боловсролтой болгож, хүүхдийн хөгжлийн талаар мэдлэгтэй болгохын тулд "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвтрүүлэг цацагдах болтугай. (Сур. 18:15)
21. Эзэн минь, бид Эсватини дахь коллеж, их сургуулиа дүүргэсэн охидын төлөө залбирч байна. Тэдэнд ажил олж, өөрсдийгөө тэжээх эх үүсвэрээ олоход нь Та туслаарай. (Еф. 3:20–21)
22. Аав аа, энэ 10-р сард Танзани улсад орон нутгийн засаг захиргааны сонгууль явагдахын төлөө бид залбирч байна. (Маг. 5:9)
23. Эзэн минь, Сомали дахь эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлэл, хавчлагаас хамгаалах болтугай. Эмэгтэйчүүдийг үнэлдэггүй, тэдэнд хор хөнөөл учруулдаг хүмүүсийн зүрх сэтгэлд өөрчлөлтийг өгөөч. (Дуу. 140:1)
24. Аав аа, бид Зимбабвегийн TWR Найдвар доторх Эмэгтэйчүүд үйлчлэлийг Танд даатгаж байна. Өмгөөлөгчдийг Ариун Сүнсээр дүүргэж, сэргээх болтугай. (Дуу. 42:1)

25. Бурхан минь, Этиоп улсад эмэгтэйчүүдийг алж буй дээрэмчдээс хамгаалаач. Энэ гэмт хэрэгтнүүд баригдаж, шийтгэгдэх болтугай. (Сур. 18:10)
26. Бурхан минь, Ботсвана дахь эрчүүд Христэд ирж, гэр орондоо сүнслэг удирдагч болоосой гэж бид залбирч байна. Тэд хань ижилдээ үнэнч байх болтугай. (Еф. 5:23)
27. Аав аа, бид Өмнөд Африкт нэн ядуу амьдарч буй эмэгтэйчүүдийн төлөө залбирч. Ядуурлаас гарах арга замыг бий болгохын тулд тэднийг ажлын байраар хангах, засгийн газрын тусламж, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болохын тулд удирдагчдын зүрх сэтгэлийг хөдөлгөөч. (Дуу. 34:6)
28. Бурхан минь, Танзани дахь Сүмийн удирдагчид өөрсдийн дагалдагчдыг TWR-ийн Найдвар доторх Эмэгтэйчүүдийн үйлчлэлийг үргэлжлүүлэн дэмжихийг урамшуулаасай гэж бид залбирч байна. (Флп. 4:15,17)
29. Аав аа, Бурундид олон эмэгтэйчүүд ажилгүй, бичиг үсэг тайлагдаагүй байна. Эмэгтэйчүүд хvvхдvvдээ, гэр бүлээ тэжээхийн тулд ажлын байраар Та хангаач. (2 Кор. 9:8)
30. Эзэн минь, Зимбабвегийн салсан гэр бүлүүдийг нэгтгэхийн тулд Ариун Сүнсний гэмшил, уучлал, эвлэрлийг авчрахын төлөө бид байна. (Еф. 4:31–32).
31. Мөнхийн Эзэн минь ээ, бид Ботсвана дахь эмэгтэйчүүдийг шүтээн шүтэх, өвөг дээдсээ шүтэхээс татгалзаж, Таныг цорын ганц жинхэнэ Бурханыг таньж мэдэн, Таны өмн ирэхийн төлөө гуйж байна. (Лев. 26:1)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. 2024/06/28нд болох Улсын их хурлын сонгуулиар Эзэн нээс эмээдэг, шударга удирдагч нар гарч, Монгол улсын өнөөгийн амьдрал өөрчлөгдөж сайн сайхан болохын төлөө залбирч байна.
2. Өсвөр насны хүүхдүүдийн хамгаалалтын төлөө. Уруу т атлага болон буруу зам руу орж амьдралдаа алдаа хийхгүй байхын төлөө. Мансууран, архи ууж буруу зүйлсийг сонирхож алдахгүй байхын төлөө залбирч байна.
3. өвөл зуднаар малаа алдсан малчдыг Эзэн та хамгаалж, хангаж амар тайвныг өгөх болтугай. 2024 онд бол ох УИХ-н сонгууль шударга болж,

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.